**БАТЛАВ**
НАЛАЙХ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Ж.АЛТАНГЭРЭЛ

2023 оны 01 дугаар сарын 22-ний өдөр

## ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

**Байршил:** **“**Гэрэлтүүлэг чимэглэлийн алба” ОНӨААТҮГ

**Ажлын цар хүрээ:** Өргөгч автомашин худалдан авах

| Үзүүлэлт | | |
|---|---|---|
| Тээврийн хэрэгслийн урт | 5,6 | Метр |
| Тээврийн хэрэгслийн өргөн | 1,9 | Метр |
| Тээврийн хэрэгслийн өндөр | 2,4 | Метр |
| Ажлын өндөр | 21,6 | Метр |
| Ажлын радиус | 14 | Метр |
| Ажлын ачаалал | 2 хүн буюу 300 кг | |
| Татаж авах өргөн | Урд: 1,8 метр / Ар тал: 1,5 метр | |
| Бүх жин | 2000 кг-аас бага | |
| Жолооны ангилал | В | |
| Нэршил | Сатари скай | |
| Үйлдвэрлэсэн он | Шинэ | |

**Захиалагчийн хяналт:**

- Тээврийн хэрэгслийн чанар, тоо хэмжээ, стандарт маркийн дагуу хугацаандаа нийлүүлэгдэж байгаа эсэхэд,
- Худалдан авах тээврийн хэрэгсэл нь олон улсын стандартын дагуу үйлдвэрлэгдсэн бөгөөд зориулалтандаа тохирсон байна.

**Гүйцэтгэгч байгуулага:**

- Нийлүүлэгч байгууллага нь техникийн үзүүлэлтийн дагуу чанартай тээврийн хэрэгслийг гэрээний хугацаанд багтаан нийлүүлнэ.
- Тээвэрлэлтийн зардал болон бусад зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.
- Тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй гэмтэл, элэгдэл хорогдлын зардлыг нийлүүлэгч байгууллага өөрөө хариуцна.
- Нийлүүлэгч байгууллага нь баталгааны хугацааг худалдан авагчид гаргаж өгнө. Баталгаат хугацаа хүлээн авсан өдрөөс эхлэн 12 сар үргэлжилнэ. Үйлдвэрлэгчээс олгосон урт хугацааны баталгааны хугацаа нь худалдан авагчид өөрчлөлтгүйгээр олгогдох ёстой.

- Автомашин нь гадна агаарын температурын $40^0$ С- $-45^0$ С-т доголдолгүй ажиллах чадвартай байх ба тормоз болон бусад тоног төхөөрөмжийн шингэн туслах материал нь $40^0$С- $-45^0$С-т ажиллах чадвартай байна. Автомашин нь үйлдвэрлэгчээс зөвлөдөг сэлбэг хэрэгсэл олдоцтой байх ба шаардлагатай тохиолдолд сэлбэг хэрэгсэл үйлдвэрлэгч, худалдан борлуулагчийн хаягийн мэдээллийг захиалагчид тодорхой болгоно. Засвар үйлчилгээ хийхэд шаардлагатай үндсэн болон тусгай багаж, хэрэгсэл нь автомашины үндсэн бүрдэл хэсэгт багтсан болно.

- Захиалагчаас шалтгаалаагүй засвар, үйлчилгээний зардлыг нийлүүлэгч бүрэн хариуцна.

- Тендерт оролцогч техникийн тодорхойлолтын маягтыг заавал өгөх ёстой бөгөөд зүйл бүрийг товхимол буюу түүнтэй дүйцэх техникийн ном хэвлэл дагалдана.

- Нийлүүлэгдэх тээврийн хэрэгслийг хүлээн авах албан ёсны арга хэмжээнд барааны үйлчилгээг шалгах, нягтлах, турших бүх үйл явц орно. Техникийн тодорхойлолтод өөрөөр заагаагүй бол нийлүүлэгчээс цахилгаан, ус, хий гэх мэт энгийн ашиглалтын зүйлсээс бусад туршилтыг явуулахад шаардлагатай бүх багаж хэрэгсэл, тос шингэн ба бусад хэрэгслээр хангах ёстой.

- Автомашины техникийн үзлэг, үйлчилгээ бүрэн хийгдэж, оношлогоонд орсон, бичиг баримт бүрэн байна.

- Нийлүүлэгдэх автомашины мэдээлэл, техникийн паспорт, машин ашиглалтын заавар, автомашины сэлбэг, эд ангийн дугаар бүхий каталоги, өнгөт зургийг хавсаргасан байна.

- Нийлүүлэгдсэн тоног төхөөрөмжийг захиалагчийн зүгээс томилогдсон ажлын хэсэг, нийлүүлэгч байгууллагатай хамтран шалган турших ажлыг зохион байгуулна.

***Дээрх техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч буцаах, хүлээн авахгүй байх арга хэмжээ авах эрхтэй.***

**ХЯНАСАН:**

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ТОХИЖИЛТ
НИЙТИЙН, АЖ АХУЙН ХЭЛТСИЙН ДАРГА /Д.ОЮУНБИЛЭГ/

**БОЛОВСРУУЛСАН:**

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН САНХҮҮ, ТӨРИЙН
САНГИЙН ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН /Б.УРАНЗАЯА/